



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

「Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны харьяа орон нутаг дахь хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой, 3 нэрийн, нийт 99,589,000.00 (ерэн есөн сая таван зуун наян есөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 50,200,000.00 (тавин сая хоёр зуун мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, хавсралтад заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг ашиглах хугацаа, үнэ шинэчлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001087
15-r huraldaan.docx

Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын 08 ны/ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Цаашид шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс								
1	Ланд крузер-200 маркийн 4544АРН улсын, JTMNU09J3B4047246 арлын дугаартай суудлын автомашин	2021-11-23	1	99,000,000.00	99,000,000.00	3	50,000,000	50,000,000
	Дүн		1	99,000,000.00	99,000,000.00	3	50,000,000	50,000,000
Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс								
1	Телевизор Mogul led 31	2012/09/30	1	439,000.00	439,000.00	3	150,000.00	150,000.00
2	Сандал CH 180J	6/1/2010	1	150,000.00	150,000.00	2	50,000.00	50,000.00
	Дүн		2	589,000	589,000.00	5	200,000	200,000
	НИЙТ ДҮН		3	99,589,000	99,589,000 (ерэн есөн сая таван зуун наян есөн мянга)	8	50,200,000	50,200,000 (тавин сая хоёр зуун мянга)